



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗУРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/07

Алтрага

Ажлыг хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх, ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнээр баталсугай.

- | | | |
|--------|---|----------------------------|
| Дарга | - | Тамгын газрын дарга |
| Гишүүд | - | Санхүүгийн албаны дарга |
| | - | Хууль эрх зүйн мэргэжилтэн |

2. Төрийн үйлчилгээний албан хаагч, гэрээт ажилтнуудын ажлын үр дүнг улирал бүр дүгнэж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Чимэдцэрэн)-д даалгасугай.

ДАРГА

Г.ОДСЭР

